



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
Утас/факс: 7555-0011
Вэбсайт: www.dmp.mn

ХАМТРАН АЖИЛЛАХ УРИЛГА

2025.11.20

Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхэд хянан хэлэлцэгдэж буй “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-тай холбогдуулан гаргасан “Худалдаа хөгжлийн банк” ХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг маргаануудад компанийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хууль зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх Өмгөөллийн хуулийн фирмтэй хамтран ажиллах нээлттэй урилгыг хүргүүлж байна.

1. Сонгон шалгаруулалт

- 1.1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаас 5 (тав)-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалт явуулах тухай зарлалыг компанийн албан ёсны www.dmp.mn цахим хуудсаар зарлан мэдээлнэ.
- 1.2. Сонгон шалгаруулалтад оролцох өмгөөлөгч /цаашид “оролцогч” гэх/-ийг бүртгэх ажиллагаа нь сонгон шалгаруулалтын товыг зарласан өдрөөс эхэлж, сонгон шалгаруулалт эхлэхээс 2 (хоёр) хоногийн өмнө дууссан байна.
- 1.3. Сонгон шалгаруулалтад оролцогч нь Өмгөөллийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтад тэнцэж, өмгөөллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, өмгөөллийн үйл ажиллагааны эрх авсан байна.
- 1.4. Сонгон шалгаруулалтад оролцогч нь өөрийн боловсрол, ажил мэргэжлийн болон туршлагын танилцуулгыг холбоо барих утасны дугаар, ажлын хаягийн хамт /PDF хэлбэрээр/ бүрдүүлж, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн албан ёсны info@dmp.mn цахим шууданд илгээнэ.
- 1.5. Бүртгэл явуулах хугацаанд багтаан мэдээллийг бүрэн ирүүлээгүй, тавигдах шаардлагыг хангаагүй болон шаардлага хангахгүй баримт ирүүлсэн бүрдүүлсэн оролцогчийг бүртгэхгүй.
- 1.6. Шаардлагатай тохиолдолд оролцогчийн бүрдүүлсэн баримт бичгийн үнэн зөв эсэхийг шалгах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтнаас тодруулна.

2. Ерөнхий шаардлага

- 2.1. Эрх зүйн дээд боловсролтой (Дээд боловсролын диплом, гадаадад төгссөн бол баталгаат орчуулга);
- 2.2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч байх;
- 2.3. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээтэй байх;

3. Тусгай шаардлага

- 3.1. Гүйцэтгэгч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байх бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй баг ажиллуулахыг шаардана.

- 3.1.1. Үйлчлүүлэгчийг шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгч-2 ба түүнээс дээш;
 - 3.1.2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй хуульч-2 ба түүнээс дээш;
 - 3.2. Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн өмгөөлөгч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.2.1. Хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил, үүнээс өмгөөлөгчийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - 3.2.2. Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан өмгөөлөгчийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хориглосон тохиолдол үүссэн эсэхийг нягтлан шалгаж, мэдэгдэл ирүүлсэн байх;
 - 3.3. Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн Хуульч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.3.1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (хуульчийн гэрчилгээ)-тэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - 3.3.2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориглосон үйлдэл гаргаж байгаагүй байх;
- 4. Гэрээ байгуулах.**
- 4.1 Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчидтой холбогдон уулзалт зохион байгуулж, хэргийн үйл баримтын талаарх мэдээллийг өгч, Худалдаа хөгжлийн банк ХХК-тай холбоотой зээлийн гэрээний хэрэг маргаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэрээний төлбөрийг харилцан тохиролцож, шийдвэрлэсний үндсэн дээр “Хууль зүйн туслалцаа үзүүлэх” гэрээг байгуулж хамтран ажиллана.

Санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Санал хүлээж авахтай холбоотой тодруулгыг
доорх цахим хаягт ирүүлнэ үү
info@dmp.mn